

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬААТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН
(2024.12.03-2025.12.05)

2025 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилго 1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна. (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.7.3), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3), (Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.1.1.11), (Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2.5, 2.6, 6.4.11, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2.6.2.1, 6.4.11.1)							
Зорилт 1.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна.							
1.1.1.	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нэмэлт хөгжүүлэлт хийх.	Урсгал зардал	Нэмэлт хөгжүүлэлт хийсэн эсэх; Систем ашиглалтын хувь	1/90	1/100	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нийт 1035 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулсан. Системд нэвтрүүлсэн визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, оршин суух зөвшөөрлийн хэлбэр өөрчлөлт, паспортын мэдээлэл өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, оршин суух үнэмлэх дахин авах, гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой үйлчилгээ авах 156,595 хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлээд байна. Мөн виз, визийн зөвшөөрөл мэдүүлэх гадаадын иргэний хүсэлт дээр Монгол Улсад байрлах хаягийн баталгаажуулалт цонхыг нэмж, орон байраар хангах иргэн, хуулийн этгээдээс холбогдох баримт бичгийг авах хөгжүүлэлтийг шинээр хөгжүүлсэн. Түүнчлэн тус системд К1-10, АЗ-10 хоногийн визийн хүсэлтийг хүлээн авах хөгжүүлэлтийг шинээр хийж, төстийн шатанд шилжүүлэн туршиж байна.	100

1	2	3	4	5	6	7	8
						Тус системийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах зорилгоор хоёр шатлалт нэвтрэлтээр хандах (2FA google authenticator) болон байнга ашиглах төхөөрөмжийг бүртгүүлэх тохиргоог 138 албан хаагч 06 дугаар сарын 11-ний өдрөөс 09 дүгээр сарын 11-ний өдрүүдэд хийсэн. Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх МОН-3936 төслийн хүрээнд 5 ширхэг сервер компьютер нийлүүлснийг Үндэсний дата төв УТҮГ-т 11 дүгээр сарын 27-ны өдөр байршуулан системийн давхар ажиллагааны серверийг үйл ажиллагаанд ашиглах бэлтгэлийг хангаж байна. Дээрх нэмэлт хөгжүүлэлтүүдийг нэвтрүүлснээр системийг 100 хувь ашиглаж байна.	
1.1.2.	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” болон цахим визийн систем (evisa)-ийн мэдээллийн сан хооронд өгөгдөл солилцох холболтыг хийх.	Урсгал зардал	Өгөгдлийн сангийн холболт хийгдсэн эсэх; Өгөгдөл солилцох визийн ангиллын тоо	-/-	1/4	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” болон цахим визийн систем (evisa)-ийн мэдээллийн сан хооронд 10 төрлийн сервисээр өгөгдөл холболтыг хийж, K2, K4, K6, K7 ангиллын 4 төрлийн виз мэдүүлэх үйлчилгээг 12 дугаар сарын 05-ны өдрөөс ажиллагаанд оруулав. Холболтын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй.	100
Зорилт 2.Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.							
1.2.1.	Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах.	Урсгал зардал	Гадаадын иргэнд Монгол Улсын виз, зөвшөөрөл олгосон хувь	100	100	Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн гадаадын 50317 иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 43979 иргэний визийн зөвшөөрлийг хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 6338 иргэний визийн зөвшөөрлийг боомт, орон нутаг дахь нэгжид илгээлээ. Хилийн боомтод 16057, төвд 23198, нийт 39255 иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон.	100

1	2	3	4	5	6	7	8
						Цахим визийн evisa.mn системээр 75 улсын 85690 иргэнд цахим виз олгож, виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан хугацаа дуусаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу шалтгаанаар 3913 иргэнд виз олгохоос татгалзсан байна.	
1.2.2.	Гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэх.	Урсгал зардал	Гадаадын иргэний бүртгэл хийж, бүртгэлд хяналт тавьсан хувь	100	100	Гадаадын иргэнийг уригч 912 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 2994 гадаадын иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 16968 гадаадын иргэний хаягийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 19193 иргэний бүртгэлд хасалт хийсэн. Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог улсын түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 802 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 3774 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. Монгол Улсад оршин суух 74412 үнэмлэхийг шинээр хэвлэсэн байна. Түүнчлэн 11105 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 32348 иргэний оршин суух зөвшөөрлийн олголт, 12720 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 37112 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, 5879 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр оршин суух зөвшөөрөлтэй 16782 иргэний бүртгэлд хасалт хийж, 210 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 226 иргэний паспортод өөрчлөлт, 165 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн оршин суух үнэмлэх дахин авах 184 иргэн, 48 цагийн бүртгэл хийлгэх 34462 иргэн, цагаачийн гарах орох мэдэгдэл хүссэн 1667 иргэний хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэсэн. “Мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж, байгууллагын даргын оршин суух зөвшөөрөл олгох тухай тушаалаар 182, оршин суух зөвшөөрөл сунгах тухай 1183, оршин суух зөвшөөрөл олгохоос татгалзах тухай тушаалаар 42 гадаадын иргэний хүсэлтийг тус тус шийдвэрлэлээ.	100

1	2	3	4	5	6	7	8
1.2.3.	Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын визийн атташе нарт “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” системд хандах эрх олгох ажлыг зохион байгуулах.	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” системд тухайн дипломат төлөөлөгчийн газарт олгогдох визийн зөвшөөрлийн жагсаалтыг харах нэмэлт хөгжүүлэлтийг хийж, Гадаад харилцааны яамнаас 02 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн жагсаалтын дагуу Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын 90 визийн атташед системд хандах эрх нээж өгсөн. Хэрэгжилт бүрэн хангагдсан.	100
1.2.4.	Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажиллагааг зохион байгуулах.	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 удаагийн зарлигаар Оросын Холбооны Улсын 1, Япон Улсын 1, Бүгд Найрамдах Хятад Улсын 1, нийт 3 иргэн Монгол Улсын харьяат болсон. Харьяат болох хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Хятад Улсын 11, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1, нийт 12 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 13 иргэний хүсэлтэд санал авахаар холбогдох байгууллагад хүргүүлсэн. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 5, Оросын Холбооны Улсын 4 иргэнтэй ярилцлага хийж, шаардлага хангасан 7 иргэний хүсэлт, холбогдох баримт бичигт дүгнэлт үйлдэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)-т хүргүүлж, 4 иргэний хүсэлт, баримт бичгийг Ерөнхийлөгчийн Тамгын газар (ЕТГ)-т уламжиллаа. Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлага хангаагүй БНХАУ-ын 4 иргэний хүсэлтийг түдгэлзүүлсэн байна. Ерөнхийлөгчийн 7 удаагийн зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан 117 иргэний мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэж, баяжилт хийлээ. Харьяатаас гарах хүсэлт гаргасан 127 иргэний хүсэлтийг хүлээн авч, 149 иргэний хүсэлт, баримт бичигт санал авахаар холбогдох байгууллагад, 131 иргэний хүсэлтийг ЗГХЭГ-т хүргүүлж, 78 иргэний хүсэлтийг ЕТГ-т уламжилсан.	100

1	2	3	4	5	6	7	8
						Ерөнхийлөгчийн 4 удаагийн зарлигаар 4 иргэн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон байна. Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 5 иргэний хүсэлтийг хүлээн авч, 5 иргэний хүсэлтийг холбогдох байгууллагад, 3 иргэний хүсэлтийг ЗГХЭГ-т тус тус хүргүүлж, 3 иргэний хүсэлтийг ЕТГ-т уламжиллаа. Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэл 100 хувь хангагдсан.	
1.2.5.	Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай гадаадын иргэний хүсэлтийг шийдвэрлэх, үрчлэлтийн дараах хяналт тавих.	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Тайлант хугацаанд Бельгийн Хаант Улсын гэр бүлд үрчлүүлсэн 1, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын гэр бүлд үрчлүүлсэн 5, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын гэр бүлд үрчлүүлсэн 1, нийт 7 хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч мэдээллийн санд бүртгэсэн. Америкийн Нэгдсэн Улсын гэр бүлд үрчлүүлсэн 1 хүүхдийг гэр бүлийнх нь хамт 05 дугаар сарын 01-ний өдөр, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын гэр бүлд үрчлүүлсэн 3 хүүхдийг 07 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын дарга хүлээн авч уулзлаа. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын харьяат 277 хүүхдийг 18 улсын гадаадын иргэн, гэр бүлд үрчлүүлээд байна. Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэл 100 хувь хангагдсан.	100
1.2.6.	Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг шийдвэрлэх, хяналт тавих.	Урсгал зардал	Зөвшөөрөл олгосон, сунгасан, хүчингүй болгосон, хяналт тавьсан ажлын гүйцэтгэл	100	100	Байгууллагын даргын дэргэдэх “Мэргэжлийн зөвлөл”-ийн 6 удаагийн хурлаар олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2 байгууллагад шинээр олгож, 36 байгууллагын зөвшөөрлийг сунган 4 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон. Нийт 74 байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн авч, хяналт тавьж ажиллалаа. Монгол Улсад өнөөдрийн байдлаар 83 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын	100

1	2	3	4	5	6	7	8
						салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа эрхэлж байна. Ажлын гүйцэтгэл 100 хувь хангагдсан.	
1.2.7.	“Иргэний харьяаллын чиглэлээр тулгамдаж буй асуудал, олон улсын чиг хандлага” сэдэвт судалгаа хийх.	Урсгал зардал	Судалгаа хийсэн эсэх	1	1	Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын баримталж буй бодлого, иргэний харьяаллын тухай хууль тогтоомжийг харьцуулан судалж, “Иргэний харьяаллын чиглэлээр тулгамдаж буй асуудал, олон улсын чиг хандлага” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.	100
1.2.8.	Гадаадын иргэн, түүнийг уригч иргэн, хуулийн этгээдэд холбогдох зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах.	Урсгал зардал	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын зохион байгуулалтын хувь	100/100	100/100	Төлөвлөгөөт 41, төлөвлөгөөт бус 253, нийт 294 удаагийн хяналт шалгалтаар 1383 аж ахуйн нэгж, байгууллага, 21831 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, 1085 зөрчлийг илрүүлэн 792 зөрчилд торгох шийтгэл оногдуулсан. Хяналт шалгалтын хүрээнд 599 гадаадын иргэнийг албадан гаргаж, 43 зөрчилд холбогдуулан албан шаардлага хүргүүлж, 80 иргэнд гарах сануулга өгсөн байна. Хяналт шалгалтын төлөвлөгөө болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын зохион байгуулалтын ажлын хэрэгжилт бүрэн хангагдсан.	100
1.2.9.	Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Урсгал зардал	Хууль зөрчсөн иргэнд авсан хориг арга хэмжээний хувь	100	100	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.2, 37.1.3, 37.1.6, 37.1.7, 37.1.8, 37.1.11, 37.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн 34 улсын 1222 иргэнийг 304 удаагийн тушаалаар албадан гаргав. Мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.4 дэх заалтыг үндэслэн 7 улсын 24 иргэний албадан гаргасан шийдвэрийг 20 удаагийн тушаалаар цуцалсан. Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2, 34.2.3 дахь заалтыг үндэслэн 9 улсын 54 иргэнийг 50 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2, 34.2.3 дахь заалтаар гарахыг түдгэлзүүлсэн 8 улсын 35 иргэний	100

1	2	3	4	5	6	7	8
						хилээр нэвтрэх эрхийг 33 удаагийн тушаалаар сэргээж, хяналт тавьж ажилласан.	
1.2.10.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24.4-т “Гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно” гэж заасныг хэрэгжүүлэх, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн тогтолцоог сайжруулж, урсгал, төвлөрөлд дүн шинжилгээ хийх Big Data үүсгэх.	Урсгал зардал	Хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд болон аялал жуулчлал, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ыг холбосон мэдээллийн систем; Big Data ашиглалтын хувь	-/-	1/90	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF)” системд 48 цагийн бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулах нэмэлт хөгжүүлэлтийг хийж, 02 дугаар сарын 18-ны өдрөөс ашиглалтад оруулсан. Цахим визийн evisa.mn системд гадаадын иргэний хаягийн баталгаажуулалтыг авах нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгүүлэхээр 19,719,700 төгрөгийн үнэ бүхий гэрээг Интерактив ХХК-тай байгуулан хаягийн баталгаажуулалтыг 03 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн талаарх сургалтыг Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх албаны 25 сургагч багшид, Зочид буудлын холбооны гишүүн 38 аж ахуйн нэгжийн төлөөлөлд 04 дүгээр сарын 03, 06 дугаар 06-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан. Монголын мэргэжлийн аялал жуулчлалын холбоотой 2 удаагийн уулзалт, Зочид буудлын холбоотой 1 удаагийн уулзалтыг тус тус хийн бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулах талаар санал авч, саналын дагуу “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нэмэлт хөгжүүлэлт хийв. Түүнчлэн тус системийг зочид буудлын системтэй холбох зорилгоор 09 дүгээр сарын 01-ний өдөр Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системд FS100113_AddressRegisterRequest дугаартай сервисийг хөгжүүлж, мэдээллийг зочид буудлын холбооны системийг хөгжүүлэгч байгууллага болох “Хореко софт ХХК”-д цахимаар хүргүүлсэн. Харьяалах нутаг дэвсгэртээ аялал жуулчлал, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд 48 цагийн бүртгэлийн талаар зөвлөмж хүргүүлэх талаар Нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 03 дугаар сарын 06-ны өдрийн 05/313 дугаар албан	100

1	2	3	4	5	6	7	8
						бичиг, 03 дугаар сарын 26-ны өдрийн 05/13 дугаар дотоод албан бичгийг тус тус хүргүүлсэн. Тайлант хугацаанд 48 цагийн бүртгэлд 34,462 гадаадын иргэнийг бүртгүүлсэн байна. Хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй.	
1.2.11.	Виз, зөвшөөрөл, зөрчил шалган шийдвэрлэлт, иргэний харьяаллын асуудлаар иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах.	Урсгал зардал	Зөвлөгөө, мэдээлэл хүргэх хэлбэр; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	3/100	4/100	Тайлант хугацаанд Монгол Улсын виз, визийн хугацааны сунгалт, албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, бүртгэлийн дугаарын олголт, ашиглалт, оршин суух үнэмлэх олгох, хэвлэх, төлбөрийн буцаалт, зөрчил шалган шийдвэрлэлт болон иргэний харьяаллын асуудлаар 87245 иргэнд утсаар, 4646 иргэнд биечлэн, 2984 иргэнд цахим шуудангаар, facebook мессенжерээр 623, хиймэл оюунт чатботоор 2092 зөвлөгөө, нийт 97590 хүсэлтэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. Түүнчлэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Тайландын Хаант Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн, Хөх хот, Оросын Холбооны Улсын Улаан-Үүд хотод суугаа Элчин сайдын яам, консулын газрын ажилтнуудад 27 удаагийн зөвлөгөө, мэдээлэл өгч, дэмжиж ажилласан.	100
Зорилт 3.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.							
1.3.1.	Гадаад харилцааг өргөжүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх.	Урсгал зардал	Байгуулсан санамж бичиг; Гадаад улсад хийсэн албан айлчлал; Дотоод уулзалт, хүлээн авалтын тоо	1/7/34	1/4/30	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Дотоод хэргийн яамны харьяа Цагаачлалын газартай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг 10 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Байгууллагын дарга тэргүүтэй төлөөлөгчид БНСУ-ын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвийн урилгаар 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 18-ны өдрүүдэд, Унгар Улсын Гадаад иргэдийн бодлого зохицуулах ерөнхий газрын урилгаар 05 дугаар сарын 05-ны өдрөөс 09-ний өдрүүдэд, Бүгд	75

1	2	3	4	5	6	7	8
						Найрамдах Хятад Ард Улсын Цагаачлалын удирдах газрын урилгаар Жянсу мужийн Ляньюньган хотноо зохион байгуулсан “Цагаачлалын удирдлагын хамтын ажиллагааны дэд форум”-д оролцох үеэр буюу 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 18-ны өдрүүдэд тус тус 3 удаагийн ажлын айлчлал хийв. Мөн байгууллагын дарга гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд, консул, олон улсын байгууллагын төлөөлөгчтэй нийт 30 удаагийн албан уулзалт хийж, холбогдох арга хэмжээнд оролцсон байна.	
1.3.2.	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Буцалтгүй тусламж	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	1/100	1/100	Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “World Friends KOICA” төслийн хүрээнд Монгол Улсад нэг жилийн хугацаанд ажиллах судлаач 07 дугаар сарын 21-ний өдрөөс үүрэгт ажлаа эхэлсэн. Тус хугацаанд судлаач байгууллагын үйл ажиллагаатай танилцан холбогдох нэгжийн дарга болон ахлах мэргэжилтнүүдтэй ажлын уулзалт хийж, Монгол Улсын цагаачлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, нэгдсэн бодлого боловсруулах асуудлаар судалгааны ажлыг эхлүүлээд байна. Түүнчлэн “Олон улсын шилжилт хөдөлгөөн дэх цахим шилжилт ба хяналтын механизм” сэдэвт судалгааг Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэнтэй хамтран боловсруулж байна.	30
1.3.3.	“Олон улсын шилжилт хөдөлгөөн дэх цахим шилжилт ба хяналтын механизм” сэдэвт судалгаа хийх.	Урсгал зардал	Судалгаа хийсэн эсэх	-	1	“Олон улсын шилжилт хөдөлгөөн дэх цахим шилжилт ба хяналтын механизм” сэдэвт судалгаа хийх хүрээнд хэсэгчилсэн байдлаар 6 судалгааны танилцуулга, 3 илтгэлийг санал дүгнэлтийн хамт боловсруулан удирдлагад танилцуулж, 3 судалгааг холбогдох нэгжид хүргүүлсэн. Үүнд: Танилцуулга: 1.Аялагч буюу жуулчин нэр томъёоны талаарх олон улсын ойлголт;	30

1	2	3	4	5	6	7	8
						2.Гадаад иргэдийн бүртгэл, хяналтын тогтолцоогоор тэргүүлэгч улсуудын талаарх танилцуулга; 3.Төрийн болон хувийн байгууллагуудын цахимжилт, түүний боловсронгуй байдал, үйлчилгээний хүртээмжтэй байдлыг үнэлж, гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагууд; 4.Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цагаачлалын байгууллагын албан хаагчдын оролцоо; 5.Гадаад улсын ижил чиг үүргийн байгууллагуудын визгүй зорчдог улсын иргэдэд зориулсан хяналтын систем; 6.Монгол Улсын иргэншилтэй бус хүнийг тодорхойлох нэр томьёо, тэдгээрийн эрх зүйн байдлыг тогтоох хуулийн тодорхойлолт; 7.Хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэний виз, оршин суух зөвшөөрлийн олон улс дахь зохицуулалт; 8.Хамаарал бүхий этгээдийн виз, оршин суух зөвшөөрлийн олон улс дахь зохицуулалт; 9.Хөрөнгө оруулагч гадаадын иргэний виз, оршин суух зөвшөөрлийн олон улс дахь зохицуулалт. Илтгэл: 1.Гадаад иргэдийн хяналт, бүртгэлийн тогтолцоог сайжруулахад баримталж буй бодлого, үйл ажиллагаа; 2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал; 3.Гадаад иргэдийн асуудлаар улс орнуудын баримталж буй бодлого, туршлага, сургамж.	
1.3.4.	Гадаад сургалт, олон улсын хурал болон туршлага солилцох уулзалтад албан хаагчдыг оролцуулах.	Буцалтгүй тусламж	Гадаад сургалтын тоо; Олон улсын хурлын тоо; Олон улсын уулзалтын тоо; Хамрагдсан албан хаагчийн тоо	12/3/6/ 67	4/2/1/30	Тайлант хугацаанд нийт 62 албан хаагчийг 4 удаагийн гадаад сургалт, 6 удаагийн олон улсын хурал, 4 удаагийн туршлага судлах уулзалтад хамруулсан. Үүнд: -БНЭУ-д англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад 1, БНСУ-ын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-аас Сөүл хотноо зохион байгуулсан “Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх нь (2023-2025)”	100

1	2	3	4	5	6	7	8
						сургалтад 15, Унгар Улсын Будапешт хотноо Гадаад иргэдийн бодлого зохицуулах ерөнхий газраас зохион байгуулсан үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах сургалтад 5, Тайваний Мин Чуан их сургуульд хятад хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад 3, нийт 24 албан хаагч; -Швейцарын холбооны улсын Женев хотноо НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит тайланг хэлэлцүүлэх, хамгаалах хурал, БНФУ-ын Манила хотноо зохион байгуулагдсан "1993 оны Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенцын хэрэгжилтийг үнэлэх, туршлага солилцох бүс нутгийн семинар", БНСУ-ын Сөүл хотноо "Ховор ашигт малтмалын олон улсын форум 2025"-д тус тус 1, АНУ-ын "Юта мужийн төрийн холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах семинар"-т 3 албан хаагч, БНСУ-ын Цагаачлал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас зохион байгуулсан "Цагаачлалын салбарын манлайлагчид" сэдэвт хуралд 2, Тайваний Дотоод хэргийн яамны Цагаачлалын албанаас зохион байгуулах "Гадаад улс орнуудын цагаачлалын албаны ажилтнуудад зориулсан 2025 оны жишиг семинар"-т 2, БНХАУ-ын Ляньюнган хотноо зохион байгуулагдсан "Цагаачлалын удирдлагын хамтын ажиллагааны дэд форум"-д 2, нийт 12 албан хаагч; -БНХАУ-д зохион байгуулагдсан "Монгол Улсын төрийн захиргааны удирдлагын семинар"-т 4, "Монгол Улсын хил хамгаалах болон цагаачлалын семинар"-т 12, "Монгол Улсын хууль зүйн салбарын албан хаагчдыг чадавхжуулах семинар"-т 5, "Боомт, орон нутгийн үйл ажиллагаатай танилцах семинар"-т 5, нийт 26 албан хаагчийг тус тус хамруулсан.	
1.3.5.	Хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын	-	100	Хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх чиглэлээр "Жендэрийн олон улсын хөтөлбөр"-т хамрагдах хүсэлтийг 01	30

1	2	3	4	5	6	7	8
	байдлыг дээшлүүлэх чиглэлээр “Жендэрийн олон улсын хөтөлбөр”-т гишүүнээр оролцох бэлтгэл ажлыг хангах.		гүйцэтгэлийн хувь			дүгээр сарын 03-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрт цахимаар хүргүүлсэн боловч тодорхой шалтгааны улмаас тус хөтөлбөрийн санхүүжилтийг 02 дугаар сарын 28-ны өдрөөс зогсоож, цаашид хөтөлбөр хэрэгжихгүй болсон талаарх хариуг авсан болно.	
1.3.6.	Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох.	Урсгал зардал	Санал хүргүүлсэн хууль тогтоомж; Боловсруулж баталсан эрх зүйн баримт бичгийн тоо	7/6	5/5	Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөл, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, нийт 4 хуулийн төсөлд санал хүргүүлсэн бөгөөд Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Улсын Их Хурлын 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар батлагдсан. Мөн дээд шатны болон холбогдох төрийн байгууллагаас ирүүлсэн журмын төсөлд 4 удаа санал боловсруулан хүргүүлсэн. Үүнд: -Засгийн газрын тогтоолын төсөл: Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт хэрэглэх журам, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай; -Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлах журмын төсөл: Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт шинэчлэн батлах тухай; -Хөрөнгө оруулалт, худалдааны газар: Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажиллах журмын төсөл. Түүнчлэн байгууллагын даргын А/168, А/226, А/564, А/565 дугаар тушаалаар “Кибер аюулгүй байдлыг хангах журам”, “Хяналтын улсын байцаагчийн ажиллах заавар”, “Бүртгэлийн хуудасны загвар”, “Мэдүүлгийн хуудасны загвар, шаардагдах баримт бичгийн жагсаалт”-ыг тус тус шинэчлэн баталж,	100

1	2	3	4	5	6	7	8
						A/231 дүгээр тушаалаар “Ёс зүй зөвлөлийн ажиллах журам”-ыг хүчингүй болгон A/252 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, нийт 6 эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох арга хэмжээ авсан. “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 192, 194 дүгээр тогтоолоор тус тус баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл боловсруулж, 10 дугаар сарын 13-ны өдрийн 01/1860 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.	
1.3.7.	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх.	Урсгал зардал	Хүргүүлсэн саналын тоо	-	1	Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, танилцуулга боловсруулж, 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/38 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.	100
1.3.8.	Монгол Улсын хилийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу хилийн боомтод үүрэг гүйцэтгэх орон нутаг дахь нэгжийн ачааллыг тэнцвэржүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний шуурхай, ил тод байдлыг хангах зорилгоор зохион байгуулалтын бүтэц, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулж, процессын	Урсгал зардал	Хамрагдсан нэгжийн тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-/-	7/100	Байгууллагын даргын 01-02/31 удирдамжийн дагуу 06 дугаар сарын 03-ны өдөр “Төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл” сэдэвт сургалтыг Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор Б.Нарантулгатай хамтран зохион байгуулж, нийт 150 орчим албан хаагчийг хамруулав. Мөн Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын ажлын ачааллыг бууруулж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор виз, зөвшөөрлийн зарим төрлийн хүсэлтийг хилийн боомт, орон нутаг дахь 6 газар, 4 хэлтсийн албан хаагчдаар гүйцэтгүүлэх, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах байгууллагын даргын 4 удаагийн тушаалаар нийт 96 албан хаагчид “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд шалгах эрх олгосон. Түүнчлэн төвийн үндсэн чиг үүргийн нэгжийн албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, хилийн боомт, орон нутаг дахь	85.7

1	2	3	4	5	6	7	8
	дахин инженерчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх.					нэгжийн албан хаагчдыг ажлын байранд сургаж, дадлагажуулах зорилгоор Виз зөвшөөрлийн газарт 28, Зөрчил шалган шийдвэрлэх газарт 23, Зөвлөгөө, мэдээллийн хэлтэст 1, Мэдээллийн технологийн хэлтэст 1, Дорноговь аймаг дахь газарт 1, давхардсан тоогоор нийт 39 албан хаагчийг байгууллагын даргын 17 удаагийн тушаалаар 1-3 сарын хугацаатай ажиллуулж сургалаа. Төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор үндсэн чиг үүргийн нэгжийн албан хаагчдын ажлын ачаалалд шинжилгээ хийж, Виз, зөвшөөрлийн газар, Иргэний харьяаллын газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн албан хаагчдын 92.8 хувь, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 94.6 хувийг хамруулсан. Шинжилгээний дүнд үндэслэн төвийн үндсэн чиг үүргийн зарим нэгжийн ачааллыг бууруулах, тэнцвэржүүлэх зорилгоор процессын дахин инженерчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх, зарим нэгжийн орон тоо, чиг үүргийг шинэчлэх стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны жагсаалт, танилцуулга, холбогдох судалгааг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1656 албан бичгээр хүргүүлсэн.	

1	2	3	4	5	6	7	8
1.3.9.	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах.	Урсгал зардал	Стратеги төлөвлөгөө батлуулсан эсэх	-	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах санал болон байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/542 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 12 дугаар сарын 06, 12, 13-ны өдрүүдэд 3 удаа зохион байгуулж, салбарын болон байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг ажлын хэсгийн тушаалын хамт 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2489 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын стратеги төлөвлөгөөг 2 удаагийн шинэчилсэн маягтын дагуу тус тус боловсруулж, 01 дүгээр сарын 03, 04 дүгээр сарын 03-ны өдөр яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлээ.	50
1.3.10.	Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” (2025-2028)-ийг шинэчлэн батлах.	Урсгал зардал	Хөтөлбөр баталсан эсэх	-	1	Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025-2028 оны хөтөлбөрийн төсөлд Захиргаа, удирдлагын газрын даргын 02 дугаар сарын 12-ны өдрийн 02/18 дугаар дотоод албан бичгээр зохион байгуулалтын нэгжүүдээс санал авч, нэгтгэснийг Даргын дэргэдэх зөвлөлийн 02 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. Байгууллагын даргын А/107 дугаар тушаалаар хөтөлбөрийг 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг зохион байгуулахаар баталсныг www.immigration.gov.mn цахим хуудас болон Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем (ERP)-д байршуулсан.	100
1.3.11.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91.4	100	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Авлигатай	97.9

1	2	3	4	5	6	7	8
	ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.					тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус байгууллагын даргаар батлуулж, Захиргаа, удирдлагын газрын 02/14 дотоод албан бичгээр төв, орон нутаг дахь нэгжийн дарга нарт хүргүүлэн байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэхтэй холбоотой чиглэлийг 05 дугаар сарын 23-ны өдрийн 02/69 дотоод албан бичгээр төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлсэн. Эхний 11 сарын байдлаар Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх 2 төлөвлөгөө, 1 чиглэлийн хэрэгжилт 93.5 хувийн гүйцэтгэлтэй. Мөн “Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог хангах нь” 2025-2030 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 6 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 11 дүгээр сарын 18-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, мөрдөн ажиллаж байна.	
1.3.12.	Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “Эрсдэлд суурилсан авлигын эсрэг төлөвлөгөө”-г 02 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу байгууллагын чиг үүрэгт хамаарах 3 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагаа хэрэгжүүлж буй бөгөөд эхний 11 сарын байдлаар хэрэгжилт 91 хувьтай. Төлөвлөгөөний хүрээнд Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын ачааллыг бууруулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор байгууллагын даргын А/114, А/145, А/158 дугаар тушаалаар виз, визийн зөвшөөрөл, Монгол Улсад	91

1	2	3	4	5	6	7	8
						албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл сунгах, оршин суух үнэмлэх дахин авах, паспортын мэдээлэл өөрчлөх, хаягийн өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хасалт хийлгүүлэх хүсэлтийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдаар цахимаар шалгуулж байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар байгууллага, нэгжийн албан тушаалтны үйл ажиллагаанд тавих олон нийтийн хяналтыг бүрдүүлэх зорилгоор байгууллагын даргын 2025 оны А/247 дугаар тушаалаар “Олон нийтийн хяналтад хамруулах чиглэл”-ийг батлан мөрдөж байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчийг албаны чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан авлигад өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах зорилгоор “Авлига, ашиг сонирхлын нөлөөллийг мэдээлэх заавар”-ыг 10 дугаар сарын 01-ний өдрийн А/440 дүгээр тушаалаар, байгууллагын даргын 2025 оны “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгаврыг тус тус батлан танилцуулах сургалтыг 10 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, албан хаагчдаар баталгаа гаргууллаа.	
1.3.13.	Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	100	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2025 оны төлөвлөгөөг Даргын дэргэдэх зөвлөлийн 02 дугаар сарын 25-ны өдрийн 1 дүгээр хурлаар хэлэлцүүлж, байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөөг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудас болон Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд нээлттэй байршуулсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулав. Үүнд: Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу төв, хилийн боомт орон нутаг дахь нэгжийн	100

1	2	3	4	5	6	7	8
						төрийн тусгай болон төрийн үйлчилгээний нийт 266 албан хаагчийн албан тушаалын үндсэн цалинг байгууллагын даргын 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 дугаар тушаалаар шинэчлэн тогтоолоо. Байгууллагын даргын 2024 оны А/407 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийг зайнаас ажиллуулах журам”-ын хүрээнд ажлын онцлог, чиг үүргээс хамаарч, холбогдох нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу 40 албан хаагчийг 7 хоног бүрийн 1 өдөр зайнаас ажиллуулж байна. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 4.17, 4.18, 4.19-д заасны дагуу 60 албан хаагчид давхардсан тоогоор 71 удаагийн олговортой чөлөө, 39 удаагийн олговоргүй чөлөө, нийт 110 удаагийн чөлөө олгосон. Байгууллагын даргын 2025 оны Б/16, Б/18, Б/79 дүгээр тушаалаар гэр бүлийн гишүүн нь нас барсан 3 албан хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгөн тусламж олгосон.	
1.3.14.	Албан хаагчдын амьжиргааны нөхцөлийг харгалзан орон сууцны урьдчилгаа, зээлийн болон түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх.	Урсгал зардал	Хамрагдсан албан хаагчийн тоо	26	25	Өмнөд бүс дэх газар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1 албан хаагчид 6.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг, 1 албан хаагчид гэр олгосон бол Дорноговь аймаг дахь газар 1 албан хаагчийг түрээслээд өмчлөх орон сууцны дэмжлэгт орон нутгийн төсвийн хөрөнгөөр хамруулсан. Шүүх шинжилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчдын орон сууцны хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 3 албан хаагчийн мэдээллийг 10 дугаар сарын 18, 30-ны өдрийн 02/1868, 01/1927 дугаар албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүллээ. Байгууллагын хэмжээнд орон сууцны урьдчилгаа болон зээлийн төлбөрийн дэмжлэг хүссэн 6, хүсэлт ирүүлээгүй боловч шинээр ипотекийн зээл авсан, түрээсийн байранд амьдардаг 6, нийт 12 албан хаагчийн судалгааг шинэчлэн гаргав. Дэмжлэг үзүүлэхтэй холбоотой санал, тооцоог гарган 2025 оны давсан орлогоос санхүүжүүлэх	30

1	2	3	4	5	6	7	8
						хүсэлтийг 11 дүгээр сарын 11-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хүргүүлсэн.	
1.3.15.	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах.	Урсгал зардал	Хамрагдсан албан хаагчийн тоо	33	100	Төв байгууллагаас “Сити фарм дэнк” ХХК-тай хамтран 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэгт 89, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн төв эмнэлэгт 09 дүгээр сарын 08, 11-ний өдрүүдэд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт 81, нийт 170 албан хаагчийг хамруулсан. Хууль зүй, дотоод хэргийн Сайдын санаачилгаар Төрийн тусгай албан хаагчийн Нэгдсэн эмнэлгээс зохион байгуулсан эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хилийн боомт, орон нутаг дахь 5 нэгжийн 66, “Хавдаргүй Монгол эмэгтэй” төслийн хүрээнд хийсэн үзлэгт 7 эмэгтэй албан хаагч, нийт 73 албан хаагч хамрагдсан. Дорноговь аймаг дахь газар 06 дугаар сарын 07-ны өдөр 13, Баруун бүс дэх газар 09 дүгээр сарын 03-ны өдөр 14, нийт 27 албан хаагчийг эрүүл мэндийн үзлэгт тус тус хамруулсан. Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд 10 удаагийн үзлэг шинжилгээнд давхардсан тоогоор 270 албан хаагчийг хамруулсан.	100
1.3.16.	Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	93.3	100	Төрийн албан хаагчийн 2025 оны сургалтын төлөвлөгөөг 6 арга хэмжээний хүрээнд 35 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу байгууллагын хэмжээнд нийт 75 удаагийн сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 2890 гаруй албан хаагчийг хамруулсан. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 7, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, нийт 17 албан хаагчийг хамруулсан. Нийт албан хаагчийн 5.8% нь удирдлагын	100

1	2	3	4	5	6	7	8
						академийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй.	
1.3.17.	Төрийн тусгай албаны албан тушаалын сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх.	Урсгал зардал	Сонгон шалгаруулалтын тоо	7	7	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасны дагуу төрийн тусгай албаны гүйцэтгэх 29 албан тушаалын сул орон тооны 5 удаагийн зарыг байгууллагын www.immigration.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Зарын дагуу 12 иргэн шилжин ажиллах хүсэлт ирүүлснээс нийт 4 албан тушаалын сул орон тоог төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа, хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлага хангасан төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхсөн. Салбар зөвлөлийн 02, 07, 08 дугаар тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалт зохион байгуулах тусгай шалгалтын комиссын хурлаар төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхөгдөөгүй 14 албан тушаалын сул орон тооны захиалгыг салбар зөвлөлийн 3 удаагийн албан бичгээр болон Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн шалгалтын цахим систем (se-admin.csc.gov.mn)-д илгээсэн. Төрийн тусгай албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөх тусгай шалгалтыг 2024 оны 12 дугаар сарын 27, 04 дүгээр сарын 29, 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулсан ба шалгалтад тэнцсэн 3 иргэний 2 нь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэний нөөц, 1 нь 2024 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэн байв. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ХЭГ/1760 албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу байгууллагын орон тоо нэмэгдүүлэхтэй холбоотой шийдвэр гаргаагүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас	71.4

1	2	3	4	5	6	7	8
						чөлөөлөгдсөн төрийн үйлчилгээний ангиллын 1 албан хаагчийн болон сул орон тоонд нөхөн томилгоо хийгээгүй, www.csc.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан төрийн тусгай албаны гүйцэтгэх 13 албан тушаалын сул орон тооны 2 удаагийн тусгай шалгалтыг байгууллагын даргын 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/1187 албан бичгээр хугацааг хойшлуулсан, хүлээгдэж байна.	
1.3.18.	Жендэрийн тэгш байдлын талаар судалгаа хийж, үр дүнд үндэслэн зорилтот арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Урсгал зардал	Судалгааны тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-/-	1/100	Байгууллагаас гарч буй бодлого, шийдвэрийн хэрэгжилт нь албан хаагчдын жендэрийн тэгш байдлыг хангасан эсэх, хүйсээс үл хамааран хүртээмжтэйгээр хэрэгжсэн эсэх, ажил, албан тушаалд томилохдоо хүйсийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримталсан эсэхэд 5 зорилтын хүрээнд харьцуулсан тэгш байдлын судалгаа хийсэн. Судалгааны дүнгээр байгууллагын хэмжээнд бэлгийн дарамт хүчирхийлэл харьцангуй бага үзүүлэлтэй байгаа нь урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтаас ангид эрх зүйн орчин, соёл, хэвшлийг төлөвшүүлсэнтэй холбоотой бөгөөд хүйсийн хувьд нийт албан хаагчдаас эрэгтэй 49%, эмэгтэй 51% нь ажил, албан тушаалд томилохдоо жендэрийн тэгш байдлыг баримталсан байна. Дээрх судалгааг 3 дугаар улирлын байдлаар шинэчлэн 11 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын даргад танилцуулж, судалгаа болон холбогдох санал, зөвлөмжийг 11 дүгээр сарын 24-ний өдрийн 08/45 дугаар дотоод бичгээр төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нарт хүргүүлсэн.	30
1.3.19.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах.	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	92	100	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын даргаар батлуулан зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлж, Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд байршуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зохион байгуулсан “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, Цагдаагийн	100

1	2	3	4	5	6	7	8
						ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас зохион байгуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт” сэдэвт сургалтад албан хаагчдыг хамруулсан. Мөн “Эрүүдэн шүүх конвенцын талаарх ойлголт”, Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигын ойлголт, түүний хор уршиг” сэдвээр тус тус сургалт зохион байгуулж, 32 албан хаагчийг хамрууллаа. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 20-ны өдөр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлсэн. Төв байгууллагын албан хаагчид болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нараас нийт 85 удаагийн “гадаад улсад зорчих албан хаагчийн баталгаа”-г гаргуулан авч, бүртгэл хөтлөн хяналт тавьж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай.	
1.3.20.	Хилийн боомт, орон нутаг дахь нэгжид байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчийг томилон ажиллуулах.	Урсгал зардал	Томилсон албан хаагчийн тоо	-	7	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээлэл солилцох, ажлын уялдааг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, хамт олонд хүлээн зөвшөөрөгдсөн албан хаагчийг сонгож ирүүлэх тухай Ёс зүйн дэд хорооны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр дотоод албан бичгийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд хүргүүлсний дагуу нийт 6 газар, 1 хэлтсээс 7 албан хаагчийн нэр ирүүлсэн. Ирүүлсэн саналыг хэлэлцэн байгууллагын даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн А/106 дугаар тушаалаар дээрх 7 албан хаагчийг ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх албан хаагчаар томилсон. Тайлант хугацаанд Дорноговь аймаг дахь газар, Баруун бүс дэх газарт дээрх чиг үүргийг хариуцан ажиллаж байгаад ажлаас чөлөөлөгдсөн болон нэгж хооронд шилжин томилогдсон албан хаагчийн оронд харьяа нэгжийн саналыг үндэслэн байгууллагын даргын А/467 дугаар тушаалаар 2 албан хаагчийг нөхөн томилон ажиллуулж байна.	100

1	2	3	4	5	6	7	8
1.3.21.	Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнд үндэслэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Урсгал зардал	Судалгааны тоо; Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-/-	1/100	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагад үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор 4 асуулт бүхий асуумжийг 02 болон 11 дүгээр сард авч, нийт 213 албан хаагчийг хамруулсан. Үр дүнд үндэслэн байгууллагын даргын “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 10 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврыг баталж, нийт албан хаагчдыг хууль тогтоомжийг мөрдөх, аливаа дарамт, шахалт, нөлөөлөлд автахгүй, ёс зүйн зөрчилд өртөхгүй ажиллах чиглэлээр үүрэгжүүлэн “Баталгааны хуудас” гаргуулсан.	100
1.3.22.	Сахилга, ёс зүйн зөрчил давтан гаргасан албан хаагчдыг дахин зөрчил, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор улирал тутам арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Урсгал зардал	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	4	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил, дутагдлыг давтан гаргахаас сэргийлэх зорилгоор байгууллагын даргын 03 дугаар 11-ний өдрийн А/118 дугаар тушаалаар батлуулсан удирдамжийн дагуу Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд 03 дугаар сарын 31-ний өдөр Агаарын замын боомт хариуцсан газарт, 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 10-ны өдрүүдэд Дорноговь аймаг дахь газарт тус тус ажиллаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албаны чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хамтарсан уулзалт зохион байгууллаа. Мөн Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу МУИС-ийн Олон улсын харилцааны тэнхимийн багш, профессор Ж.Баттогтохтой “Манлайлагчийн ёс зүй”, Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн их хамба ламын Ажлын албаны дарга, гавж	100

1	2	3	4	5	6	7	8
						Д.Нямсамбуутай “Хувь хүний ёс суртахуун”, сэтгэл судлаач Д.Оюунноминтой “Харилцаа, ёс зүй ба бидний хандлага”, Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор А.Алтанзултай “Төрийн үнэ цэн, төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага” сэдэвт сургалтуудыг тус тус хамтран зохион байгууллаа. Түүнчлэн Захиргаа, удирдлагын газрын дарга 10 дугаар сарын 10-ны өдөр нийт албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй, авлига ашиг сонирхлын зөрчил” сэдэвт сургалт хийсэн. Зохион байгуулсан 5 удаагийн сургалтад танхим болон цахимаар давхардсан тоогоор 423 албан хаагч хамрагдсан.	
1.3.23.	Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх.	Урсгал зардал	Байгууллагын цахим хуудаст нийтэлсэн мэдээллийн тоо; Олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан мэдээллийн тоо; Сурталчилсан тоо	155/17 5/467	150/120/3 00	Тайлант хугацаанд үйл ажиллагаатай холбоотой 84 мэдээ бэлтгэж, байгууллагын цахим хуудаст нийт 160 мэдээ, ярилцлага, видео, нээлттэй мэдээлэл байршуулан олон нийтэд мэдээллээ. Бэлтгэсэн мэдээллийг давхардсан тоогоор 609 хэвлэл мэдээллийн хэрэгслээр (546 сайт, 28 сонин, 35 телевиз) сурталчилсан. Тухайлбал, “Виз, визийн зөвшөөрөл олголт 98.4 хувьтай байна” гарчигтай мэдээг 13 сайт, 2 телевиз, “Гадаадын 653,545 иргэнд цахимаар үйлчилгээ үзүүллээ” мэдээг 11 сайт, 1 телевиз, 2 сонин, “Өнгөрөгч онд 25 улсын 998 гадаадын иргэнийг албадан гаргалаа” гарчигтай мэдээг 24 сайт, 3 телевиз, “Гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг киоск машинаас хэвлэж авах боломжтой боллоо” мэдээг 19 сайт, 2 телевиз, 2 сонин, “Интерполоор эрэн сурвалжлагдаж байсан БНСУ-ын иргэнийг хяналт шалгалтаар илрүүллээ” мэдээг 25 сайт, 2 телевиз, 2 сонинд нийтлүүлж, олон нийтэд мэдээлсэн. Байгууллагын дарга 03 дугаар сарын 27-ны өдөр tsahiur.mn сайтад цахим виз олголт, 04 дүгээр сарын 29-ны өдөр tv5 телевизэд хил дээрээс буцаасан гадаадын иргэдийн асуудлаар, хяналтын улсын ахлах байцаагч 11 дүгээр сарын 18-ны өдөр МҮОНТ-	100

1	2	3	4	5	6	7	8
						д гадаадын иргэдийн нөхцөл байдал, зөрчил шалган шийдвэрлэх асуудлаар ярилцлага өгөв. Байгууллагын даргын 05 дугаар сарын 26-ны өдрийн “Аян зохион байгуулах тухай” А/242 дугаар тушаалын дагуу “Бүртгэл-хариуцлага, хамгаалалт” нөлөөллийн аяныг 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулж, аяны хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын бүртгэлийн хариуцлагыг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 14 постер (зурагт хуудаст), 6 видео контент бэлтгэж, олон нийтэд хүргэсэн. Аяны талаарх мэдээллийг 10 сайтад нийтлүүлсэн. Олон нийтийн сүлжээн дэх байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийг сурталчилсан 246 мэдээлэл байршуулсан ба мэдээллийн дундаж түгээлт 142 байна. Цахим хуудаст тогтмол мэдээлэл байршуулж, түгээлт хийснээр байгууллагын цахим хуудасны дагагчийн тоо 36 мянга, дундаж хандалтын тоо 141,100 болж өслөө.	
1.3.24.	Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдлийг боловсруулж, системд сар бүр нийтлэх.	Урсгал зардал	Нээлттэй өгөгдлийн тоо; Нийтэлсэн тоо	11/12	11/12	“Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ын дагуу дагуу мэдээлэл хариуцагчийн сар бүр нийтлэх 11 төрлийн өгөгдлийг 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01-11 дүгээр сарын байдлаар XLSX, CSV, JSON өргөтгөлөөр тус тус боловсруулж, холбогдох хугацаанд байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д нийтэллээ.	100
1.3.25.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх.	Урсгал зардал	Шийдвэрлэлтийн хувь	96.5	100	Тайлант хугацаанд байгууллагын төвд 762 (иргэнээс 577 өргөдөл, 3 талархал, 2 санал, 8 хүсэлт, 56 гомдол, албан хаагчдаас 115 өргөдөл, 1 мэдээлэл), хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 192 (иргэнээс 48 өргөдөл, 1 гомдол, албан хаагчдаас 143 өргөдөл), нийт 954 өргөдлийг хүлээн авч, 928 өргөдлийг шийдвэрлэсэн байна. Үүнээс Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс манай байгууллагад 3 талархал, 2	97.2

1	2	3	4	5	6	7	8
						санал, 8 хүсэлт, 56 гомдол шилжүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт өссөн дүнгээр 97.2 хувьтай, хуулийн хугацаанд буюу шийдвэрлэх шатанд 26 өргөдөл хянагдаж байна.	
1.3.26.	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Урсгал зардал	Үнэлгээ хийсэн тоо; Хяналт-шинжилгээний тайлангийн тоо	23/23	22/22	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 19 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайланг тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлэв. Үүнд: -“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн арга хэмжээ, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2024 оны жилийн эцэс, 2025 оны хагас жилийн хэрэгжилт, нэмэлт тайлбар, нотломжийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох зүйл, заалтуудын 01 дүгээр сар болон нэгдүгээр улирлын хэрэгжилт, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын гуравдугаар улирлын хэрэгжилтэд 09 дүгээр сарын 25-ны өдөр, 10 дугаар сарын 03-ны өдөр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулсан. -Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2024 оны жилийн эцэс, гуравдугаар улирлын хэрэгжилтэд 02 дугаар сарын 05-ны өдөр, 04 дүгээр сарын 04-ний өдөр, 09 дүгээр сарын 15-ны өдөр, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2025 оны тайлан”, 09 дүгээр сарын 19-ний өдөр тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн удирдлагад танилцуулав. Мөн байгууллагын даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/459 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, байгууллагын хэмжээнд хүчин	86.3

1	2	3	4	5	6	7	8
						төгөлдөр мөрдөгдөж байгаа тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлтэд хяналт-шинжилгээ хийсэн тайлан, санал дүгнэлтийг 01/1988 дугаар албан бичгээр 11 дүгээр сарын 05-ны өдөр Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт, хуулбарыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	
1.3.27.	Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Урсгал зардал	Үнэлгээ хийсэн тоо; Хяналт-шинжилгээний тайлангийн тоо	18/18	18-аас доошгүй/ 18-аас доошгүй	Байгууллагын үйл ажиллагаанд 26 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох хугацаанд байгууллагын даргад танилцуулсан. Үүнд: - Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд; - Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний биелэлтэд; - Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөө болон хөтөлбөрийн биелэлтэд; - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт; - 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 01-11 дүгээр сарын үйл ажиллагаанд; - Байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах, төвийн нэгжийн удирдах албан тушаалтны харилцаа, хандлага, ур чадварыг тодорхойлох чиглэлээр судалгаа шинжилгээ; - Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024, 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ хийж, зөвлөмжийг 08/39 дүгээр дотоод албан бичгээр төвийн 8 нэгжид хүргүүлсэн. - Виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэхэд бүрдүүлэх материал, түүний давхардалд хяналт-шинжилгээ хийж, удирдлагаас өгсөн чиглэлийг Захиргаа, удирдлагын газарт 08/39 дүгээр дотоод албан бичгээр уламжилсан. - Төв, орон нутгийн нэгжийн дарга нарын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I улирал, хагас жил, гуравдугаар улирлын биелэлтэд;	100

1	2	3	4	5	6	7	8
						- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын 2025 оны хагас жилийн байдлаарх шийдвэрлэлтэд; - Монгол Улсад хөрөнгө оруулагч, суралцах хэлбэрээр оршин суугаа гадаадын иргэн түүний хамаарал бүхий этгээдийн бүртгэл, хяналтад судалгаа, шинжилгээ хийж, 09 дүгээр сарын 25-ны өдрийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар танилцуулга хийсэн. - Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем (egr)-д нийтэлсэн мэдээлэлтэй танилцсан албан хаагчдын тоонд хяналт-шинжилгээ хийж, газар нэгжүүдэд 02/111 дүгээр дотоод албан бичгээр чиглэл хүргүүлсэн.	
1.3.28.	Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх.	Урсгал зардал	Тайлангийн тоо; Эрсдэлийг сааруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2/92.5	2-оос доошгүй/ 95	Байгууллагын эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 89.15 хувьтай үнэлэгдэж, эрсдэлийн үнэлгээний хагас жил болон жилийн эцсийн тайланг 06 дугаар сарын 09-ний өдрийн 08/1125, 12 дугаар сарын 02-ны өдрийн 08/2144 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.	91.5
1.3.29.	Нийцлийн болон санхүүгийн аудитын хяналт шалгалтыг зохион байгуулах.	Урсгал зардал	Хяналт шалгалтын тоо; Хүргүүлсэн зөвлөмжийн биелэлтийн тоо	9/9	9-өөс доошгүй/ 9-өөс доошгүй	Байгууллагын дотоод аудитын төлөвлөгөөний дагуу Агаарын замын боомт хариуцсан газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс, Дорноговь аймаг дахь газар, Зүүн бүс дэх газар, Хойд бүс дэх газар, Өмнөд бүс дэх газарт санхүүгийн чиглэлээр 6, нийцлийн чиглэлээр 3, Санхүү, хангалт үйлчилгээний газар болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 4, нийт 13 удаагийн төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад танилцуулан, холбогдох нэгжүүдэд нийт 10 зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг хангуулсан байна. Санхүү, хангалт үйлчилгээний газар, хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг үнэлж, 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01-08/01, 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/08-13, 09	100

1	2	3	4	5	6	7	8
						дүгээр сарын 09-ний өдрийн 01-08/24 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан.	
1.3.30.	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны статистикийн эмхэтгэл гаргах.	Урсгал зардал	Эмхэтгэл гаргасан эсэх	1	1-ээс доошгүй	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны статистик эмхэтгэлийг гаргаж, үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн 2 минутын видео контент бэлтгэн төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем (ERP)-д нийтэлж, албан хаагчдад танилцуулсан.	100
1.3.31.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.	Урсгал зардал	Батлагдсан төсвийн дүн	17.5 тэрбум	17 тэрбум	Энэ онд 20,757.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 07 дугаар сард төсөвт тодотгол хийгдэж, 18,844.1 сая төгрөгөөр шинэчлэн батлагдсан. 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 14,523.0 сая төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулан 14,357.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 01/490, 01/813, 01/1015, 01/1499, 01/1698, 01/1861, 01/2091 дүгээр албан бичгээр 7 удаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, холбогдох зардлыг шийдвэрлүүлсэн. Түүнчлэн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2026 оны төсвийн төслийн саналыг урт хугацааны бодлогын баримт бичигт үндэслэн боловсруулж, 28,640.8 сая төгрөгөөр төлөвлөн тайлбар, танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд 07 дугаар сарын 07-ны өдрийн 01/1271 дүгээр албан бичгээр хүргүүлсэн ба 2026 оны төсөв 20,236.1 сая төгрөгөөр батлагдсан.	100
1.3.32.	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудын нэгтгэсэн тайлан балансыг нэгтгэн, холбогдох байгууллагаар санхүүгийн аудит хийлгэж, тодруулга, тайлбар гаргах.	Урсгал зардал	Зөвлөмж; Акт; Албан шаардлага авсан эсэх (өсөлт, бууралт)	6/2/2	6/2/2 бууруулна	Харьяа 7 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хяналт тавьж, 19 харилцагч аж ахуйн нэгж, байгууллагатай тооцоо нийлэн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулсныг 01/488 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч ажилласан ба нэгтгэсэн санхүүгийн тайланд 1 зөвлөмж, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд 3 албан шаардлага, 3 зөвлөмж авч, өмнөх	99

1	2	3	4	5	6	7	8
						оноос зөрчлийн тоо хэмжээг бууруулж ажилласан. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг 01/618 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Сангийн яамны цахим системд байршуулж баталгаажуулсан.	
1.3.33.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан худалдан авах ажиллагааны 2025 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах.	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 дугаар тушаалаар баталсан 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 1,990.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу 5 төсөл арга хэмжээг www.tender.gov.mn цахим хуудсаар нээлттэй зарлаж, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан бараа, ажил үйлчилгээг хүлээн авч, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 4 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон. Мэдээллийн технологийн үйлчилгээний төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд бүрэн гүйцэтгэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж баталгаажуулсан ба санхүүжилтийг олгуулахаар холбогдох дээд шатны байгууллагуудад хүсэлт хүргүүлээд байна. Албан хаагчдын дүрэмт хувцас бэлтгэн нийлүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд дүрэмт хувцасны загварыг шинэчлэн хийлгэж, Хууль зүй дотоод хэргийн сайдаар батлуулах бэлтгэл ажлыг хангасан бөгөөд тус төсөл, арга хэмжээний төсвийг хэмнэж, 2026 онд худалдан авалт хийхээр төлөвлөөд байна. Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хилийн боомтод виз олгоход шаардагдах тоног төхөөрөмж” худалдан авах 1.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 багц төсөл арга хэмжээг www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулж, 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Худалдан авах ажиллагааны явцын мэдээг сар бүр, тайланг хагас жил тутам Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, сар бүр www.shilendans.gov.mn системд холбогдох мэдээллийг байршуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувьтай байна.	91

1	2	3	4	5	6	7	8
1.3.34.	Тэмдэгтийн хураамжийн орлого, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхэд хяналт тавих.	Урсгал зардал	Төвлөрүүлсэн орлогын дүн	25 тэрбум төгрөг	15 тэрбум төгрөг	Тайлант хугацаанд 28,267.1 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж, 3,431.4 сая төгрөгийн торгуулийн орлого, нийт 31,698.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, виз, оршин суух үйлчилгээний хураамж болох 3,889.5 сая төгрөгийг улсын төсвийн дансанд тус тус төвлөрүүлж, орлого төвлөрүүлэлтэд сар бүр хяналт тавьж ажилласан.	100
Зорилго 2.Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. (Шинэ сэргэлтийн бодлого-Төрийн бүтээмжийн сэргэлт 6.1), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3.2)							
Зорилт 1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.							
2.1.1.	Мэдээллийн аюулгүй байдлын стандарт MNS ISO270001:2023 нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах.	Урсгал зардал	Боловсруулсан журмын тоо	-	10	Байгууллагын даргын 2025 оны А/168 дугаар тушаалаар “Кибер аюулгүй байдлыг хангах журам”, А/476 дугаар тушаалаар “Мэдээллийн системийн нөөцлөлт ба нөхөн сэргээх журам”, А/475 дугаар тушаалаар “Кибер халдлага зөрчлийн үед хариу арга хэмжээ авах журам”, А/593 дугаар тушаалаар “Сүлжээний аюулгүй байдлын журам”, А/594 дүгээр тушаалаар “Хандалтын бүртгэл, аудитын журам”, А/595 дугаар тушаалаар “Сервер өрөөний аюулгүй байдлын журам”, А/596 дугаар тушаалаар “Эцсийн хэрэглэгчийн төхөөрөмжийн аюулгүй байдлын журам”, А/597 дугаар тушаалаар “Нууц үгийн бодлого ба нэвтрэлтийн журам”, А/598 дугаар тушаалаар “Өгөгдөл дамжуулах ба хадгалах аюулгүй байдлын журам”, А/599 дүгээр тушаалаар “Програм хангамж, шинэчлэл, туршилтын орчны журам”-ыг тус тус шинээр баталж, мөрдөн ажиллаж байна. Хэрэгжилт бүрэн хангагдсан.	100
2.1.2.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Data Loss Prevention, Azure	Урсгал зардал	Программ нэвтрүүлсэн эсэх; Холбогдсон хэрэглэгчийн тоо	-/-	1/130	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ-аас зарласан ДГАЗҮСЗДТГ/20250102036 дугаартай 345,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтаар шалгарсан гүйцэтгэгч байгууллагаас Microsoft 365 E5 оффисын программын нийт 130 ширхэг лицензийг хүлээн авч, Microsoft 365-ийн Data Loss Prevention (DLP) буюу байгууллагын мэдрэмтгий өгөгдлийг (sensitive data)	100

1	2	3	4	5	6	7	8
	технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх.					хамгаалж, алдаатай эсвэл зөвшөөрөлгүйгээр алдагдах явдлыг хянах, зогсоох зорилготой аюулгүй байдлын функцийг тохируулан төвийн 60, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 70, нийт 130 албан хаагчийн компьютерт суулгасан.	
2.1.3.	Төрийн байгууллагууд хооронд өгөгдөл солилцоог автоматжуулсан интерфейс (API) хөгжүүлэх.	Урсгал зардал	Байгууллагын тоо; Хөгжүүлэлтийн тоо	-/-	8/18	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан “Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ” болон нэмэлт гэрээний дагуу нийт 45 удаагийн хөгжүүлэлт хийж, 6 байгууллагын 32 төрлийн сервисээр мэдээлэл авч, 25 байгууллагад 13 төрлийн сервисээр мэдээлэл өгч байна.	75
2.1.4.	Гадаадын иргэний урсгал, чиглэл, шилжилт хөдөлгөөний бүртгэл хяналтыг нэгтгэн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг үе шаттай зохион байгуулж, цаашид дүн шинжилгээ хийх нөхцөл, боломжийг бүрдүүлэх.	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	Гадаадын иргэний урсгал, чиглэл, шилжилт хөдөлгөөний бүртгэл хяналтыг нэгтгэн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг үе шаттай зохион байгуулж, цаашид дүн шинжилгээ хийх нөхцөл, боломжийг бүрдүүлэх хүрээнд Хил хамгаалах ерөнхий газраас 01 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн хил нэвтрэлтийн 20,707,761 мөр бичлэг бүхий мэдээллийг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд хөрвүүлэн оруулсан. Тус мэдээллийг хөрвүүлснээр “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системээс Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэдийн тоон мэдээллийг боомт тус бүрээр харах боломжтой болсон. Мөн Монгол Улсад авто тээврийн хэрэгсэл эзэмшигч гадаадын иргэдийн мэдээллийг авахаар Авто тээврийн үндэсний төвд 05 дугаар сарын 26-ны өдрийн 05/1012 дугаар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд 08 дугаар сарын 22-ны өдрийн 05/1516 дугаар, “Жолоочийн бүртгэл, мэдээллийн сан”-д бүртгэгдсэн Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхтэй гадаад улсын иргэдийн мэдээллийг авахаар Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл, хяналтын төвд 09 дүгээр сарын 15-ны өдрийн 05/1648 дугаар албан бичгээр тус тус хандаж, хамтран ажиллаж байна. Хэрэгжилт 80 хувийн гүйцэтгэлтэй.	80

1	2	3	4	5	6	7	8
2.1.5.	Хилийн боомтод виз мэдүүлэх, олгох киоск машиныг үйлчилгээнд нэвтрүүлэх.	Урсгал зардал	Байршуулсан киоск машины тоо; Ашиглалтын хувь	-/-	41/100	Тоног төхөөрөмж худалдан авах ГИХГ/20240102010 дугаартай тендер шалгаруулалтыг зарлан гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулж, хилийн боомтод виз мэдүүлэх, олгох 41 киоск машиныг 04 сарын 26-ны өдөр хүлээн авсан. Киоск машинд суурилуулах программ хангамжийн хөгжүүлэлтийн ГИХГ/20250103004 дугаартай тендерийг 04 дүгээр сарын 24-ний өдөр зарлан шалгарсан байгууллагатай 05 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулж, хөгжүүлэлтийг 12 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авч, киоск машинуудад программ хангамжийг суулган ашиглалтад бэлэн болгосон. Хөрөнгийг төв байгууллагаас хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн балансад шилжүүлэх хүсэлтийг 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2124 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хэрэгжилт 95 хувийн гүйцэтгэлтэй.	50
2.1.6.	Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэх.	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь; Хэвлэх төхөөрөмжийн тоо	-/-	100/1	Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд олгох оршин суух үнэмлэх хэвлэх 1 киоск төхөөрөмжийг 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Эдийн засаг, хөгжлийн яамны хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвд байршуулж, үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн оршин суух үнэмлэх хэвлэх 1 төхөөрөмжийг Гадаад харилцааны яаманд хүлээлгэн өгсөн бөгөөд тус яамны Ёслолын газарт дипломат албан, хаагчдын оршин суух үнэмлэхийг хэвлэж байна. Тайлант хугацаанд гадаадын иргэний 74,412 ширхэг оршин суух үнэмлэх хэвлэсэн байна. Хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй.	100
2.1.7.	Хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан чатбот хөгжүүлэн зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд нэвтрүүлэх.	Урсгал зардал	Үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх; Хөгжүүлэлтийн тоо	-/-	1/1	Хиймэл оюунт чатботын системийг зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээнд нэвтрүүлэх 01/09-14 дугаартай гэрээг Макснет ХХК-тай 04 дүгээр сарын 18-ны өдөр байгуулан чатбот хөгжүүлж, “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” систем, цахим хуудас (immigration.gov.mn) болон Facebook хуудаст 08 дугаар сарын 24-ний өдөр холбон үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.	100

1	2	3	4	5	6	7	8
						Тус хугацаанд хиймэл оюунт чатботоор 2092 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. Хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй.	
2.1.8.	Зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний чанарыг сайжруулж, албан хаагчдыг мэргэшүүлэх.	Урсгал зардал	Алдсан дуудлагын хувь; Зохион байгуулсан сургалтын тоо; Хамрагдсан албан хаагчийн тоо	13%/1/ 16	6.5%/3/36	Зөвлөгөө, мэдээллийн 1800-1882 лавлах утсаар хандсан нийт 90434 дуудлагаас 87245 дуудлагад хариу өгч, 3189 дуудлагыг алдсан байна. Нийт дуудлагад эзлэх алдсан дуудлага 3.6 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зөвлөгөө, мэдээллийн чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх хүрээнд 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01-02/04 дүгээр удирдамжийн дагуу 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 24-ний өдрүүдэд, 05 дугаар сарын 19-ний өдрийн 01-10/01 дүгээр удирдамжийн дагуу 05 дугаар сарын 22-ны өдөр цахимаар, 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01-10/02 дугаар удирдамжийн дагуу 11 дүгээр сарын 27-ны өдөр нийт 3 удаагийн чадавхжуулах сургалт зохион байгуулж, 117 албан хаагчийг хамруулсан. Мөн бусад төрийн болон хувийн хэвшлийн 5 байгууллагын захиалгаар 5 удаагийн хичээл, сургалт зохион байгуулж, 123 албан хаагч, ажилтанд холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулж, зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн.	100
2 зорилго, 4 зорилт, 55 ажил, арга хэмжээ							
Үнэлгээ: 88.9 хувь							